



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ЭНХТҮВШИН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.01.22 № ХЭГ/219
танай 2024/2.20 -ны № 45 -Т

Хариу хүргүүлэх тухай

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Сангийн сайд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хавсралт //.. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255001527



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.12.31 № 01/10913
танай _____ -ны № ХЭГ/2692 -т

Хариу өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн ирүүлсэн Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх асуулгад хариу ирүүлэх тухай Таны 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ХЭГ/2692 тоот албан бичигтэй танилцаад уг тогтоолоор батлагдсан үндсэн чиглэлд тусгагдсан тус яамнаас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр дамжуулж нээлттэй худалдах асуудлын хүрээнд холбогдох мэдээллийг хүргүүлж байна.

Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-д тус яамнаас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг "Төрийн банк" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны 20 хүртэл хувь, "Монголын Хөрөнгийн бирж" ХК, "Үндэсний давхар даатгал" ХК-ийн 34 хүртэл хувийг биржээр дамжуулан олон нийтэд худалдах асуудлыг үе шаттай авч хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд энэ хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангуулах үүднээс "Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол батлагдсан.

Энэ хүрээнд "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Төрийн банк" ХХК-ийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай" 04 дүгээр тогтоол батлагдаж, тус банкны нийт хувьцааны 5.71 хувьтай тэнцэх хувьцааг нэмж гарган 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалсан болно.

"Төрийн банк" ХК-ийн нэмж гаргасан нэгж хувьцааны үнийг 590 төгрөгөөр тогтоон олон нийтэд санал болгосон бөгөөд хөрөнгийн биржийн нээлттэй арилжааны үр дүнд 7,423 хөрөнгө оруулагчдаас нийт 25.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлсэн байна.

2. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны 34 хүртэл хувийг 2022 оны 4 дүгээр улиралд багтааж олон нийтэд худалдах ажлыг зохион байгуулахыг Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид үүрэг болгосон.

9762004761

Энэ хүрээнд тус компанийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хувьцааг нэмж гарган нэгж хувьцааны үнийн дүн 100 төгрөг байхаар тогтоож 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдсан бөгөөд ингэснээр, тус компани 7,086 хувьцаа эзэмшигчтэй болж, хөрөнгийн биржийн нээлттэй арилжааны үр дүнд 11.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлсэн байна.


3. Түүнчлэн тус яамнаас хувьцаа эзэмшигчийн эрхийг дангаар хэрэгжүүлдэг "Үндэсний давхар даатгал" ХК-ийн хувьцааны 34 хүртэл хувийг биржээр дамжуулан 2023 оны 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд нээлттэй худалдах ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн болно.

Үүнтэй холбогдуулан компанийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах бэлтгэл ажлыг уг тогтоолд заасан хугацаанд бүрэн хангасан бөгөөд үнэт цаасны зах зээлийн өнөөгийн төлөв байдал болон биржээр дамжиж нээлттэй хувьцаат компани болсон аж ахуйн нэгжүүдийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ, нэгж хувьцааны ханшийн бууралт зэргээс шалтгаалж тус компанийг нээлттэй хувьцаат компани болгох ажлыг хойшлуулахаар Засгийн газрын 2023 оны 382 дугаар тогтоолоор тус тус шийдвэрлэсэн болно.

4. Компанийн засаглал, үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор "Төрийн банк" ХК, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигчдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг хүргүүлж, энэ хүрээнд жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллөөс бүрдсэн хяналтын зөвлөлийг байгуулж, хяналтын зөвлөлийн ажиллах журам болон уг бүтэц зохион байгуулалттай холбоотой өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгаж, нийт хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлаад байна.

Хяналтын зөвлөл нь нийт хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс банкны үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн чиг үүрэгтэй болно.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381

Утас: (976-51) 26 23 50,

Цахим шуудан: info@pcsp.gov.mn,

Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2025.01.10 № А-1/96
танай _____-ны № _____-т


Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингээс Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” асуулгын хариуг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшинд уламжилж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт 8 хуудастай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

133030170

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ 16 ДУГААР ТОГТООЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 244 ДҮГЭЭР ТОГТООЛУУДЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолын төслийг Сангийн яамнаас боловсруулж, бүх яамд болон Монголбанкнаас санал авч, батлуулсан болно.

“Төрийн банк” ХХК-ийн хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, тодорхой хувийг олон нийтэд нээлттэй арилжаалах, арилжаалсан орлогоор банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, олон нийтийн компанийн засаглалыг бий болгох зорилгоор “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкийг 2021-2023 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Сангийн яамнаас боловсруулж, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 65 дугаар тэмдэглэл гарсан бөгөөд уг хуралдааны дараа тус тогтоолын төслийн нэрийг “Төрийн өмчит банкийг олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” болгон өөрчилсөн.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы хуралдаанаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан “Төрийн банк” ХХК-ийг нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д заасны дагуу Төрийн банк” ХХК-ийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх асуудлаар “Төрийн өмчит банкийг олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, гарах зардлын тооцоог Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.

Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.

Дээрх 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгтгэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хуралд өргөн барьсаны дагуу хэлэлцэн Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан болно.

Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолын төсөлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох саналыг тухай бүр хүргүүлж байсан.

Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоол гарсан.

Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 336 дугаар тогтоол гарч, эдгээр компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирал нарт компанийн үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжихтай холбоотой бэлтгэх ажлыг хангах, мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулах асуудлыг Үнэт цаасны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах зөвшөөрөл олгосон болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Төрийн өмчит компанийн шинэчлэл-IPO” сэдвийн хүрээнд 25 компанийн удирдах ажилтнуудад “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн хурлын зааланд сургалт, хэлэлцүүлгийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсээс зохион байгуулж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн ба 11 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж”-ээр биржээр худалдах, IPO хийх ажлын бэлтгэл ямар байгаа, өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил, үнэт цаасаа хөрөнгийн зах зээл дээр арилжаалах бэлтгэл ажлыг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар тодорхой чиглэлүүдийг хүргүүлэн ажилласан.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоолын хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хэрэгжилтийн талаар	Биелэлт
1	“Төрийн банк” ХК	“Төрийн банк” ХХК нь нийт хувьцааныхаа 5.71%-ийг олон нийтэд нээлттэй арилжиж 7,306 хувь хүн, аж ахуйн нэгжийн 67.3 тэрбум төгрөг буюу 22.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас 3 дахин өндөр дүнтэйгээр давж биелэн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан.	100%
2	“Монголын хөрөнгийн бирж” ХК	Монголын хөрөнгийн бирж нь нийт хувьцааныхаа 34%-ийг олон нийтэд нээлттэй арилжиж 7,414 хувь хүн, аж ахуйн нэгжийн	100%

		57.8 тэрбум төгрөг буюу 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас 4.8 дахин өндөр дүнтэйгээр давж биелэн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан.	
3	“Үндэсний давхар даатгал” ХК	Мэргэжлийн байгууллагуудаас Үнэт цаасны танилцуулгыг бэлэн болгож, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс анхдагч зах зээлийн арилжааг хийх зөвшөөрөл олгосон боловч зөвшөөрлийн хугацаанд анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлж чадаагүй үндсэн шалтгаан нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Аливаа этгээд дангаараа болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.” гэж заасны дагуу хөрөнгө оруулагч нь дангаар болон холбогдох этгээдийн хамт нийт хувьцааны 5% болон түүнээс дээш хувийг эзэмшихийг хуулиар хориглосонтой холбоотой.	Анхдагч зах зээлд арилжих бэлтгэл ажил хийгдэж байна.
4	“Монголын цахилгаан холбоо” ХК	Мэргэжлийн байгууллагуудаас Үнэт цаасны танилцуулгыг бэлэн болгож, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс анхдагч зах зээлийн арилжааг хийх зөвшөөрөл олгосон боловч зөвшөөрлийн хугацаанд анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлж чадаагүй үндсэн шалтгаан нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Аливаа этгээд дангаараа болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.” гэж заасны дагуу хөрөнгө оруулагч нь дангаар болон холбогдох этгээдийн хамт нийт хувьцааны 5% болон түүнээс дээш хувийг эзэмшихийг хуулиар хориглосонтой холбоотой.	Анхдагч зах зээлд арилжих бэлтгэл ажил хийгдэж байна.
5	“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК	“Мэдээлэл, холбоо сүлжээ” ТӨХХК нь стратегийн дэд бүтэц эзэмшигч компани тул IPO гаргах жагсаалтаас хасч өөр хэлбэрээр олон нийтийн хяналтын зохистой оролцоог бий болгохоор төлөвлөж байна.	Эхний ээлжинд хаалттай ХК болгох
6	“Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ	“Мэдээлэл, технологийн үйлдвэрийн парк” ТӨҮГ нь салбарын инновац, инкубатор төв тул IPO гаргах жагсаалтаас хасч өөр хэлбэрээр олон нийтийн хяналтын зохистой оролцоог бий болгохоор төлөвлөж байна.	Салбарын яамны оролцоог нэмэгдүүлэх замаар ХК болгох
7	Авто замын засвар арчлалтын 20 компани	Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор Авто замын засвар арчлалтын 20 төрийн өмчит компаниудыг нэгтгэж “А33А нэгтгэл” ТӨХК-ийг байгуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 153 дугаар тогтоолоор 20 А33А компанийн	Стратегийн хөрөнгө оруулалт татах нөхцлийг бүрдүүлэх,

	<p>Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зогсоож, Төлөөлөн удирдах зөвлөлийн 72 гишүүнийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдрөөр чөлөөлж, 20 компанийг “АЗЗА нэгтгэл” ТӨХК-ийн охин компанийн хэлбэрээр ажиллуулахаар шийдвэрлэсэн. Улмаар ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 661 дүгээр тогтоолоор “АЗЗА нэгтгэл” ТӨХК-ийн охин компаниудыг татан буулгаж, 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс “АЗЗА нэгтгэл” ТӨХК-ийн салбар хэлбэрээр ажиллуулахаар дүрмийг шинэчлэн баталсан. Цаашид “АЗЗА нэгтгэл” ТӨХК-ийн хэмжээнд IPO гаргахаар бэлтгэл хангаж ажиллаж байна.</p>	<p>үнэ цэнийг нэмэгдүүлэх, бэлтгэл хангах</p>
--	---	---

Үндсэн чиглэлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалах ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой цаашид анхаарах дараахь асуудлууд байна. Үүнд:

- Төрийн өмчит хуулийн этгээдийн статусыг өөрчлөх, зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох, өр төлбөрийг цэгцлэх, орлого, үр ашгийг нэмэгдүүлэх замаар компанийн хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх;
- Тухайн компанийн нийт хөрөнгө, үйл ажиллагааны цар хүрээ, салбарын онцлогийг харгалзан стратегийн хөрөнгө оруулагч буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувь хэмжээ /5%/ -г оновчтой тогтоох;
- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй байгаа компаниудыг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах эсвэл засаглал, үр ашиг, олон нийтийн хяналтыг сайжруулах өөр хэлбэрийг сонгох;
- Банкуудын IPO-той холбоотойгоор Монголын хөрөнгийн биржийн багтаамжийг харгалзан үзэж хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд арилжих цаг хугацааг дахин авч үзэх шаардлагатай байна.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



**УИХ-ЫН 2015 ОНЫ
70-Р ТОГТООЛ (17)**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьцлааг, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" 70 дугаар тогтоол

ДЦС-4 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-2 ТӨХК, Дархан ДЦС ТӨХК, Эрдэнэт ДЦС ТӨХК, УБЦТСүлжээ ТӨХК, Диспетчерийн үндэсний төв, Шивээ овоо ХК, Багануур ХК, ЭТТ ХК, Оргил Рашаан сувилал ТӨХК, КУДС ХХК, ХААБирж ХК, Автоимпэкс ХК, Монгол шуудан ТӨХК, Монголын цахилгаан холбоо ХК, "Хөтөлийн цемент шохой" ТӨХК зэрэг 17 төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааны 30-100%-ийг худалдахаар үндсэн чиглэлийг баталсан



**УИХ-ЫН 2015 ОНЫ
102-Р ТОГТООЛ (+2)**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьцлааг, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 102 дугаар тогтоол

1. Төрийн банк ХХК-ний төрийн эзэмшлийн нийт хувьцааг арилжих гэж үндсэн чиглэлд нэмсэн
2. Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ны төрийн эзэмшлийн нийт хувьцааг хувьцлааг гэж үндсэн чиглэлд нэмсэн



**МУЭГ-ЫН 2015 ОНЫ
330-Р ТОГТООЛ**

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 330 дугаар тогтоолоор батлагдсан "2015-2016 онд хувьцлааг, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай"

15 төрийн өмчит хуулийн этгээдийг хувьцлахаар шийдвэрлэсэн. Үүнээс "Оргил рашаан сувилал" ТӨХК, "Кино урлагын дээд сургууль" ХХК, "Хөтөлийн цемент шохой" ТӨХК-ийг хувьчилсан.



**УИХ-ЫН 2016 ОНЫ
64-Р ТОГТООЛ (+1)**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьцлааг, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай" 64 дугаар тогтоол

1. "Монгол шуудан" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдах гэж үндсэн чиглэлийг өөрчлөн найруулсан
2. "Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн хувьцааг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах гэж үндсэн чиглэлд нэмсэн


2015 оноос хойш "Оргил рашаан сувилал" ТӨХК, "Кино урлагын дээд сургууль" ХХК, "Хөтөлийн цемент шохой" ТӨХК, "Монгол шуудан" ХК, "Төрийн банк" ХК, "Монголын хөрөнгийн бирж" ХК зэрэг нийт 6 төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг нийтэд нь болон тодорхой хувь хэмжээг худалдсан. Харин өнөөдрийн байдлаар хуулийн этгээдийг үндсэн чиглэлд тодорхой хувийг хувьцлааг, өөрчлөн зохион байгуулахаар заасан боловч хувьцлалыг хэрэгжүүлээгүй 14 төрийн өмчит компани байна.








Жич: "Хөтөлийн цемент шохой" ТӨХК-ийн хувьцлалыг Засгийн газрын 2022 оны 124 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 108 дугаар тогтоолоор хүчингүй болгоод байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН "ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛГИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬЦААГ 2022-2023 ОНД БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ" 16 ДУГААР ТОГТООЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 06 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН "ТӨРИЙН МЭДЛГИЙН ХУВЬЦААГ 2022-2023 ОНД БИРЖЭЭР ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛГИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ" 244 ДҮГЭЭР ТОГТООЛУУДЫН ХҮРЭЭНД ДАРААХ ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН 34 ХҮРТЭЛГХ ХУВИЙГ ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХААР ШИЙДВЭРЛЭСЭН. ҮҮНД:

Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн "Төрийн өмчит хуульгийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн "Төрийн мэдлгийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуульгийн этгээдийн жагсаалт батлах тухай" 244 дүгээр тогтоолуудын хүрээнд дараах төрийн өмчит компаниудын 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар шийдвэрлэсэн. Үүнд:

34 ХҮРТЭЛГХ ХУВИЙГ ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХУДАЛДАХ



-  "Төрийн банк" ТӨХХК (20% хүртэл)
-  "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК (34% хүртэл)
-  "Монголын цахилгаан холбоо" ХК (34% хүртэл)
-  "Үндэсний давхар даатгал" ТӨХК (34% хүртэл)
-  "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК (34% хүртэл)
-  "Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨҮГ (34% хүртэл)
-  Авто зам, засвар арчлалтын (АЗЗА) 20 ТӨХК (34% хүртэл)

НИЙТ 26 ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ





УИХ-ЫН 2022 ОНЫ
16-Р ТОГТООЛ



МУЗГ-ЫН 2022 ОНЫ
244-Р ТОГТООЛ

ИРО-И ТАВАНТӨГ

Төрийн өмчит компаниудын 34% хуртлал хувийн хувьцааг биржээр дамжуулан
олон нийтэд нээлттэй арилжих ажлын талаар

Холбогдох судалгаа, урьдчилсан бэлтгэл хангах	Төрийн Банк	34%	20%	+30.6%	34%	34%	34%	34%
Бэлтгэл ажлын төлөвлөгөө	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
Зөвлөлх үйлчилгээ	✓	✓	✓	✓	ТӨХХ хэлбэрт шилжүүлэх	ТӨХХ хэлбэрт шилжүүлэх	20 АЗЗА компаниудын нийлүүлэн “Автозамын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХХ байгуулсан, Цаашид тус нэгтгэл компанийн хүрээнд ИРО гаргахаар бэлтгэл хангаж байна.	“ЭРДЭНЭТ ТАВАНТӨГ” ХК
Үнэт цаасны танилцуулга	✓	✓	✓	✓	СТРАТЕГИЙН ДЭД БҮТЭЦ ЭЗЭМШИГЧ БОЛОН САЛБАРЫН ОЙШЛОГОТой БАЙГУУЛЛАГА	САЛБАРЫН ОЙШЛОГТой БАЙГУУЛЛАГА САЛБАРЫН ЯМНЫ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ХК БОЛГОХ	ЭХНИЙ ЭЭЛЖИНД ХААЛТТАЙ ХУВЬЦЛАТ КОМПАНИ БОЛГОХ	“ЭРДЭНЭТ ТАВАНТӨГ” ХК
Эрх бүхий этгээдийн бүртгэл	✓	✓	✓	✓			САЛБАРЫН ОЙШЛОГТой БАЙГУУЛЛАГА	“ЭРДЭНЭТ ТАВАНТӨГ” ХК
Үнэт цаасыг олон нийтэд сурталчлах	✓	✓	АНХДАГЧ ЗАХ ЭЗЭЛД АРИЛЖИХ БЭЛТГЭЛ АЖЛУУД ХИЙГДЭЖ БАЙНА	АНХДАГЧ ЗАХ ЭЗЭЛД АРИЛЖИХ БЭЛТГЭЛ АЖЛУУД ХИЙГДЭЖ БАЙНА			БЭЛТГЭЛ ХАНГАХ СТРАТЕГИЙН Х/О ТАТАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ	“ЭРДЭНЭТ ТАВАНТӨГ” ХК
Үнэт цаасны арилжааны захиалга хүлээн авах	✓	✓						“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ТӨХХК
Арилжааг зохион байгуулах	✓	✓					ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	“ХӨДӨӨ АЖ АХУЙН КОРПОРАЦИ” ТӨХХК
	АМЖИЛТТАЙ БОЛСОН	АМЖИЛТТАЙ БОЛСОН						



“ЭРДЭНЭТ
ҮЙЛДВЭР” ТӨҮГ



“ЭРДЭНЭС
ТАВАНТӨГ” ХК



“МОНГОЛРОСЦВЕТМЕТ”
ТӨҮГ



“ХӨДӨӨ АЖ АХУЙН
БИРЖ” ТӨХХК



“ХӨДӨӨ АЖ АХУЙН
КОРПОРАЦИ” ТӨХХК



ӨНӨРӨГИЙН НӨХЦӨЛ ВЭЛЭГ

Олон нийтийн компани болгоход анхаарах асуудал



Тухайн компанийн нийт хөрөнгө, үйл ажиллагааны цар хүрээ, салбарын онцлогийг харгалзан стратегийн хөрөнгө оруулагч буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувь хэмжээ /5%-г оновчтой тогтоох;



Статусыг өөрчлөх, бүтцийг оновчтой болгох, ер төлбөрийг цэгцлэх, орлого, үр ашгийг нэмэгдүүлэх замаар компанийн хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх;



Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй байгаа компаниудыг нэгтгэх, өөрчлөн зохион байгуулах эсвэл засаглал, үр ашиг, олон нийтийн хяналтыг сайжруулах өөр хэлбэрийг сонгох.



Банкнудын IPO-той холбоотойгоор Монголын хөрөнгийн биржийн багтаамжийг харгалзан үзэж хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд арилжих цаг хугацааг дахин авч үзэх шаардлагатай байна.